

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/137/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбаатар Утас: 261628 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Б энд С аудит ХХК Захирал: Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ж.ГАНБААТАР ТАНАА

2023.02.17 № 07/280
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 6 удирдах, 30 гүйцэтгэх, нийт 36 орон тоо батлагдсанаас 2 гүйцэтгэх ажилтныг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлж, гүйцэтгэх албан тушаалд 28 ажилтан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Гудамж төслийн хүрээнд хэрэгжсэн, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн балансад бүртгэлтэй 11,291,064.1 мянган төгрөгийн хөрөнгөнөөс 2022 онд 8,305,510.6 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэн балансаас хасаж, 2,985,553.5 мянган төгрөгийн хөрөнгө үлдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 75.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,604,794,758.62	26,729,759,846.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	263,785,654.57	266,602,161.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	263,785,654.57	266,602,161.99
3121	Төгрөг	263,785,654.57	266,602,161.99
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	263,785,654.57	266,602,161.99
33	АВЛАГА	132,418,861.00	1,215,150.06
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
335	Бусад авлага	132,418,861.00	1,215,150.06
3351	Байгууллагаас авах авлага	132,418,861.00	1,215,150.06
34	УРЬДЧИЛГАА	62,669,305.00	89,300,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	62,669,305.00	89,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	97,378,043.78	71,658,056.21
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
354	Хангамжийн материал	97,378,043.78	71,658,056.21
35410	Бичиг хэргийн материал	14,223,870.00	10,179,176.00
35420	Аж ахуйн материал	29,915,060.00	21,554,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	12,819,500.00	1,737,700.00
35440	Түлш, шатах тослох материал	3,388,207.89	2,871,564.32
35470	Бусад хангамжийн материал	37,031,405.89	35,315,365.89
36	НӨӨЦИЙН БАРАА	24,048,542,894.27	26,300,984,478.40
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	24,048,542,894.27	26,300,984,478.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	803,948,047.78	760,145,339.25
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	803,948,047.78	760,145,339.25
392	Биет хөрөнгө	803,727,611.10	759,808,616.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,083,900,000.00	1,226,158,861.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	498,272,062.42	623,203,023.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	610,571,973.76	411,829,429.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	420,411,814.47	265,708,357.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,289,400.00	57,841,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	45,349,885.77	47,110,191.90
393	Биет бус хөрөнгө	220,436.68	336,722.27
39301	Програм хангамж	11,595,330.00	12,079,330.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	11,374,893.32	11,742,607.73
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,408,742,806.40	27,489,905,185.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	263,785,654.57	266,602,161.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	263,785,654.57	266,602,161.99
413	Өглөг	263,785,654.57	266,602,161.99
4136	Бусад өглөг	263,785,654.57	266,602,161.99
41361	Байгууллагад төлөх өглөг	263,785,654.57	266,602,161.99
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,144,957,151.83	27,223,303,023.92
51	Засгийн газрын хувь оролцоо	25,144,957,151.83	27,223,303,023.92
512	Хуримтлагдсан үр дүн	25,144,957,151.83	27,223,303,023.92
51210	Өмнөх үеийн үр дүн	20,847,620,340.42	25,144,957,151.83
51220	Тайлант үеийн үр дүн	4,297,336,811.41	2,078,345,872.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,408,742,806.40	27,489,905,185.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,915,573,162.19	19,278,667,142.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,359,173,517.19	15,404,952,883.37
120	Нийтлэг татварын бус орлого	3,359,173,517.19	15,404,952,883.37
1200018	Үнэ төлбөргүй орлого	3,032,635,685.67	12,943,270,819.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,818,970.52	248,178,755.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	53,818,970.52	248,178,755.18
120009	Бусад орлого	272,718,861.00	2,213,503,308.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,556,399,645.00	3,873,714,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,556,399,645.00	3,873,714,259.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,439,422,000.00	3,497,900,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,116,977,645.00	375,813,559.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,301,558,406.80	3,283,075,827.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,301,558,406.80	3,283,075,827.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,089,062,287.67	2,412,874,769.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,177,212.24	1,380,475,667.57
210102	Нэмэгдэл	1,253,177,212.24	1,380,475,667.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,223,507.44	171,003,090.11
210201	Тэтгэврийн даатгал	113,117,951.96	117,101,870.97
210202	Тэтгэмжийн даатгал	12,578,051.51	13,776,690.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,035,561.71	11,021,352.58
210204	Ажилгүйдлийн даатгал	2,408,358.38	2,645,743.26
210205	Эрүүл мэндийн даатгал	24,083,583.88	26,457,432.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,874,755.53	162,415,247.71
210304	Байрны түрээс	143,874,755.53	162,415,247.71
2104	Хангамж, бараа материалын зардал	54,110,439.81	40,701,978.75
210401	Бичиг хэрэг	18,037,176.20	10,749,216.00
210402	Тээвэр, шатахуун	6,412,900.60	6,660,565.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,706,760.66	18,122,389.35
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,953,602.35	5,169,808.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,005,067.25	72,632,130.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,355,430.00	16,323,530.00
210604	Урсгал засвар	35,649,637.25	56,308,600.00
2107	Томилолт, зочны зардал	86,901,930.00	195,560,055.00
210701	Гадаад албан томилолт	-	47,372,271.00
210702	Дотоод албан томилолт	86,901,930.00	148,187,784.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	145,168,144.00	157,576,487.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	113,920,610.00	120,623,954.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,222,080.00	13,858,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	665,304.00	2,264,203.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,272,150.00	5,774,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,601,231.40	232,510,112.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,610,500.00	495,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	181,990,731.40	232,015,112.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,212,496,119.13	870,201,058.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,212,496,119.13	870,201,058.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,212,496,119.13	870,201,058.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,614,014,755.39	15,995,591,314.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,316,677,943.98	13,917,245,442.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		225,645,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,316,677,943.98	13,691,600,442.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(3,316,677,943.98)	(13,917,245,442.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,297,336,811.41	2,078,345,872.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	7,696,699,645.00	6,094,723,931.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,300,000.00	2,221,009,672.31
120	Нийтлэг татварын бус орлого	140,300,000.00	2,221,009,672.31
120009	Бусад орлого	140,300,000.00	2,221,009,672.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,556,399,645.00	3,873,714,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,556,399,645.00	3,873,714,259.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,439,422,000.00	3,497,900,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,116,977,645.00	375,813,559.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,380,403,355.00	3,477,215,810.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,380,403,355.00	3,477,215,810.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,185,217,235.87	2,607,014,751.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,177,212.24	1,381,740,481.88
210102	Нэмэгдэл	1,253,177,212.24	1,381,740,481.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,223,507.44	171,003,090.09
210201	Тэтгэврийн даатгал	162,223,507.44	171,003,090.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,874,755.53	163,165,168.77
210304	Байрны түрээс	143,874,755.53	163,165,168.77
2104	Хангамж, бараа материалын зардал	64,532,878.66	33,117,957.69
210401	Бичиг хэрэг	17,127,500.00	6,143,300.00
210402	Тээвэр, шатахуун	5,096,080.00	5,996,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,762,760.66	17,835,547.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,546,538.00	3,142,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,340,600.00	53,196,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,847,380.00	7,700,000.00
210604	Урсгал засвар	46,593,220.00	45,496,600.00
2107	Томилолт, зочны зардал	92,745,163.00	194,720,469.71
210701	Гадаад албан томилолт		47,797,500.00
210702	Дотоод албан томилолт	92,745,163.00	146,922,969.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	393,073,119.00	609,575,983.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	361,178,485.00	572,030,909.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,222,080.00	13,858,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	665,304.00	2,264,203.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,919,250.00	6,367,041.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,250,000.00	495,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	495,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,195,186,119.13	870,201,058.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,195,186,119.13	870,201,058.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,195,186,119.13	870,201,058.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,316,296,290.00	2,617,508,121.31
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,479,457,449.00	2,614,691,613.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,479,457,449.00	2,614,691,613.89
2200	Дотоод эх үүсвэрээр	4,479,457,449.00	2,614,691,613.89
220001	Барилга байгууламж	1,375,641,360.00	2,577,947,810.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,044,797,444.00	15,161,903.89
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,018,645.00	21,581,900.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(4,479,457,449.00)	(2,614,691,613.89)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(163,161,159.00)	2,816,507.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	426,946,813.57	263,785,654.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	263,785,654.57	266,602,161.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	20,761,240,182.42	20,761,240,182.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	86,380,158.00	86,380,158.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	20,847,620,340.42	20,847,620,340.42
Тайлант үеийн үр дүн	0.00	4,297,336,811.41	0.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	25,144,957,151.83	20,847,620,340.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	25,144,957,151.83	25,144,957,151.83
Тайлант үеийн үр дүн	0.00	2,078,345,872.09	2,078,345,872.09
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	27,223,303,023.92	27,223,303,023.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,873,714,259.00	3,004,410,210.89	869,304,048.11	77.6
УРСГАЛ ЗАРДАЛ	3,873,714,259.00	3,004,410,210.89	869,304,048.11	77.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,497,900,700.00	2,628,596,651.89	869,304,048.11	75.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,908,725,000.00	1,381,740,481.88	526,984,518.12	72.4
Нэмэгдэл	1,908,725,000.00	1,381,740,481.88	526,984,518.12	72.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,678,000.00	171,003,090.09	86,674,909.91	66.4
Тэтгэврийн даатгал	181,328,900.00	171,003,090.09	10,325,809.91	94.3
Тэтгэмжийн даатгал	19,087,300.00		19,087,300.00	-
ҮОМШӨ-ний даатгал	15,269,800.00		15,269,800.00	-
Ажилгүйдлийн даатгал	3,817,500.00		3,817,500.00	-
Эрүүл мэндийн даатгал	38,174,500.00		38,174,500.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,991,800.00	163,165,168.77	1,826,631.23	98.9
Байрны түрээс	164,991,800.00	163,165,168.77	1,826,631.23	98.9
Хангамж, бараа материалын зардал	57,532,900.00	33,117,957.69	24,414,942.31	57.6
Бичиг хэрэг	10,234,200.00	6,143,300.00	4,090,900.00	60.0
Тээвэр, шатахуун	11,127,500.00	5,996,500.00	5,131,000.00	53.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,702,700.00	17,835,547.69	12,867,152.31	58.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,468,500.00	3,142,610.00	2,325,890.00	57.5
Эд хогшил, урсгал засварын зардал	141,829,400.00	74,294,500.00	67,534,900.00	52.4
Багаж, техник, хэрэгсэл	80,268,600.00	21,097,900.00	59,170,700.00	26.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,448,400.00	7,700,000.00	6,748,400.00	53.3
Урсгал засвар	47,112,400.00	45,496,600.00	1,615,800.00	96.6
Томилолт, зочны зардал	250,429,800.00	194,720,469.71	55,709,330.29	77.8
Дотоод албан томилолт	201,779,800.00	146,922,969.71	54,856,830.29	72.8
Гадаад албан томилолт	48,650,000.00	47,797,500.00	852,500.00	98.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	661,060,800.00	610,059,983.75	51,000,816.25	92.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	615,934,500.00	572,030,909.09	43,903,590.91	92.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	15,000,000.00	13,858,830.00	1,141,170.00	92.4
Тээврийн хэрэгслийн татвар	3,000,000.00	2,264,203.00	735,797.00	75.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	55,000.00	245,000.00	18.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,826,300.00	6,851,041.66	4,975,258.34	57.9
Бараа үйлчилгээний бусад зардал	55,653,000.00	495,000.00	55,158,000.00	0.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,653,000.00	495,000.00	55,158,000.00	0.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,873,714,259.00	3,004,410,210.89	869,304,048.11	77.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,497,900,700.00	2,628,596,651.89	869,304,048.11	75.1
Улсын төсвөөс санхүүжих	3,497,900,700.00	2,628,596,651.89	869,304,048.11	75.1
Хөрөнгийн санхүүжилт	375,813,559.00	375,813,559.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		263,785,654.57	(263,785,654.57)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		266,602,161.99	(266,602,161.99)	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	34.00	2.00	94.4
Удирдах ажилтан	6.00	6.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	30.00	28.00	2.00	93.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 112,740.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 2,396.0 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 94,349.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 15,995.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтын зардал 446.0 мянган төгрөгөөр илүү олгосон.	1	446.0	1	446.0								
Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь дээд байгууллагын шийдвэрээр бусад байгууллагын албан хаагчдын гадаад албан томилолтын зардалд 47,797.5 мянган төгрөгийг олгож, төслийн хөрөнгийг үргүй зарцуулсан.	1	47,797.5			1	47,797.5						
Байгууллагын үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй Land cruiser-200 /УНИ 03-74/ автомашин, Toyota Alphard /УИВ 00-45/ авто машинууд бодитоор оршин байхгүй, мөн 33,389.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, зардалд тайлагнасан.	1	33,389.7			1	33,389.7						
Авто машины резин дугуйны өмнөх оны үлдэгдэл 27 ширхэг, тайлант онд худалдан авсан 21 ширхэг, нийт 48 ширхэг 15,995.0 мянган төгрөгийн дугуйг явсан км тодорхойгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй мөн 15 ширхэг дугуйг нягтлан бодогч нэр дээрээ зарлагын падааныг бөөн дүнгээр зарлагадсан байна.	1	15,995.0					1	15,995.0				
Тайлант онд Хендай старекс маркийн 01-54 УБҮ улсын дугаартай автомашинд 9 дүгээр сард 5, 10 дугаар сард 5, нийт 10 дугуй худалдан авч зарлагадан 1,950.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.	1	1,950.0	1	1,950.00								
Өмнөх оны үлдэгдэл болох 5,462.1 мянган төгрөгийн ажлын хувцсыг ажилчдад олгосон жагсаалт болон шаардах хуудасгүйгээр зарлагадсан, мөн тайлант онд 7,700.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч нөөц бүрдүүлсэн.	1	13,162.1			1	13,162.10						
Дүн	6	112,740.3	2	2,396.0	3	94,349.3	1	15,995.0				

